



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 617

Улаанбаатар хот

“Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн
2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,
хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2021 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирлыг түр хавсран гүйцэтгэгч Б.Батбаярт даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА


Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн
6/7 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ӨВӨРХАНГАЙ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2021 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ГҮВШИН

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Х/н	2019 оны гүйцэтгэл	2020 оны		2021 оны төлөвлөгөө	Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл		2021 төл/ 2020 ХБГ	2021 төл/ 2020 ХБГ
1	Нийт орлого	мян.төг	3,002,760.0	2,300,000.0	2,842,700.0	2,100,000.0	73.9	(742,700.0)
2	Улсын чанартай авто зам засвар арчлалтын ажил	мян.төг	2,135,610.0	1,600,000.0	2,008,459.6	1,900,000.0	94.6	(108,459.6)
3	Орон нутгийн чанартай авто зам засвар арчлалтын ажил	мян.төг	867,150.0	700,000.0	834,240.4	200,000.0	24.0	(634,240.4)
4	Нийт зардал	мян.төг	2,942,705.0	2,254,000.0	2,785,846.0	2,037,000.0	73.1	(748,846.0)
5	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	277,227.8	297,851.6	286,197.3	281,043.4	98.2	(5,153.9)
6	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	60,055.0	46,000.0	56,854.0	63,000.0	110.8	6,146.0
7	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	54,049.0	41,400.0	51,168.6	56,700.0	110.8	5,531.4
8	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	355,000.0	310,000.0	352,500.0	281,460.0	79.8	(71,040.0)
9	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	10,810.0	8,280.0	10,233.7	11,340.0	110.8	1,106.3
10	Нийт ажиллагсдын тоо	хүн	48	48	47	47	100.0	-
11	Нийт цалингийн сан	мян.төг	512,227.0	515,000.0	547,656.0	514,796.6	94.0	(32,859.4)
12	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	889.3	894.1	971.0	912.8	94.0	(58.3)
13	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.98	0.98	0.98	0.97	99.0	(0.0)
14	Хөрөнгө оруулалт	мян.төг	125,000.0	205,000.0	205,000.0	165,000.0	80.5	(40,000.0)
15	Нийт авлага	мян.төг	100,000.0	98,000.0	94,000.0	93,000.0	98.9	(1,000.0)
16	Нийт өглөг	мян.төг	255,001.5	250,001.5	238,501.5	236,001.5	99.0	(2,500.0)
17	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	95,000.0	90,000.0	78,500.0	76,000.0	96.8	(2,500.0)
18	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	160,001.5	160,001.5	160,001.5	160,001.5	100.0	-

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн
617 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



"ӨВӨРХАНГАЙ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (мян.төг)	Нийт үнэ (мян.төг)
1	Өөрөө ачигч	ш	1	120,000.0	120,000.0
2	Автогрейдерийн мотор	ком	1	45,000.0	45,000.0
	Нийт үнэ		2		165,000.0 (Нэг зуун жаран таван сая төгрөг)